

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах нөхцөлтэй сумын төвийн авто зам, 7 км /Архангай,Өндөр-Улаан сум/ зураг төсөл боловсруулах, авто замын барилгын ажил.

Тендер шалгаруулалтын дугаар: ЗТХЯ/202103028

Зам, тээврийн хөгжлийн яам нь Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХҮ.1.1.65-д заасан Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сумын төвийн авто зам, 7 км /Архангай, Өндөр-Улаан/” зураг төсөл боловсруулах, авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу зохион байгуулагдана.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50.000 (тавин мянга) төгрөгөөр цахимаар худалдаж авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- Сүүлийн 3 жилийн буюу 2018, 2019, 2020 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: 500.0 сая төгрөг байна.
- Тендерийн баталгааны үнийн дүн 63 000 000 төгрөг байна.

*Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:*

1. Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

2.8.1.5. Хөдөө орон нутгийн замын зураг төсөл боловсруулах зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбарыг нотариатаар гэрчлүүлж тамга, тэмдгээр баталгаажуулж ирүүлнэ.

2. Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

2.8.2.1.2. 5 км-ээс 15 км хүртэл хатуу хучилттай авто зам барих зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбарыг нотариатаар гэрчлүүлж тамга, тэмдгээр баталгаажуулж ирүүлнэ.

Тендерийг 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 10.30 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн талаарх нэмэлт мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11, Засгийн газрын байр 13, Зам, тээврийн хөгжлийн яам 401 тоот, Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Д.Оюунбилэг

Утас-62263207, Факс-11312315